



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/154

Бат-Өлзий сум

Хорио цээр тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын ой бүхий 16000 га талбайд Улсын төсвөөр, 7875 га талбайд Орон нутгийн төсвөөр “Гранд Форест” хязгаарлагдмал хариуцлагатай компани ойн хортон шавж устгалын ажлыг гүйцэтгэх болсонтой холбогдуулан ой бүхий газруудад 2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 30 хүртэлх хугацаанд хорио цээр тогтоосугай.

2.Хорио цээр тогтоосон ойн сан бүхий газарт гадаад дотоодын аялагч иргэд, мал оруулахгүй байхыг малчин, мал бүхий иргэд, аялагч нарт сурталчлан ажиллахыг Багийн Засаг дарга (Ж.Нямтогтох, Д.Бямбасүрэн, С.Төмөр, Г.Пүрэвтогтох, Г.Бямбагарав, Д.Дэмиддагва) нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль хамгаалагч (Ж.Батмөнх, Б.Энхмаа), Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч (Х.Чулуунбат, М.Мөнхдалай, Ш.Баасансүрэн, Б.Цэдэнбал, Ц.Төмөрхуяг) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН